Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад худалдан авалтыг зохион байгуулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 15-ны хооронд Өлзийт экаунт аудит ХХК-ийн Аудитор Ч.Эрдэнэжав, туслах аудитор Б.Лхагвасүрэн, Б.Отгонномин-Эрдэнэ нар гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Ц.Бямбажав тус тус хэрэгжүүлсэн.

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 25 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн нь Монголын уламжлалт анагаах ухааны үндэсний болон олон улсад өрсөлдөх чадвар бүхий анагаах ухаан болгох алсын хараа, Монголын уламжлалт анагаах ухааны мэдлэг, туршлага, оюуны баялаг өв санг орчин үеийн судалгаа шинжилгээний аргуудаар нотолгоожуулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй хүргэх эрхэм зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Шинжлэх ухаан технологийн хүрээлэн болон Ардын уламжлалт эмнэлгийн үйл ажиллагаануудын хувьд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцэж үйл ажиллагааны онцлогт тохирч байгаа боловч эмийн үйлдвэрлэлийн хувьд нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй, үйл ажиллагааны онцлогт тохирохгүй байна.

Боловсрол шинжлэх ухааны яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2021 онд Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй, дотоод аудиторын тайланд ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар дурдсан зүйл байхгүй, харин тус хүрээлэнгийн дотоод хяналтын ажилтны тайланд худалдан авах үйл ажиллагаа нь хуулийн дагуу хийгдэж байгаа эсэх, шилэн дансны тайлант оны ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар дурдсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашигласан ба, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл их гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 3,416,477.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 34,164.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн 2021 оны жилийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,178,807.0 мянган төгрөгөөр буюу 44.8 хувиар өсөж, материаллаг өөрчлөлт гарсан бусад авлага, урьдчилж төлсөн зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	2,351.1	2,351.1
Авлага	59,369.7	418,520.0	359,150.3
Урьдчилж төлсөн төлбөр	145,656.1	84,842.0	(60,814.1)
Бараа материал	362,999.6	543,630.0	180,630.1
Үндсэн хөрөнгө	2,058,140.7	2,755,630.3	697,489.6
Нийт хөрөнгө	2,626,166.1	3,804,973.0	1,178,807.0

Өр төлбөр	180.1	17,854.4	17,674.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,625,986.1	3,787,118.6	1,161,132.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,626,166.1	3,804,973.0	1,178,807.0

Дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлага дансны үлдэгдэл 418,520.0 мянган төгрөг болж 359,150.3 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах төлбөрт үйлчилгээний авлага 312,812.3 мянга, татаас санхүүжилтийн авлага 5,000.0 мянга, уламжлалт эмийн авлага 39,839.6 мянга, тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийн авлага 22,230.0 мянган төгрөгөөс шалтгаалжээ.
- Урьдчилж төлсөн төлбөр дансны үлдэгдэл 84,842.0 мянган төгрөг болж буурсан нь эрдэм шинжилгээний төслийн ажлыг хүлээлгэн өгсөн 35,627.3 мянга, Гачуурт дахь сувиллын байрыг хүлээлгэн өгсөн 33,028.1 мянган төгрөгөөр буурсан;
- Бараа материалын дансны үлдэгдэл 543,629.7 мянган төгрөг болж 180,630.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 700,354.8 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан 220,288.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, акталсан 12,727.7 мянга, зарцуулсан 1,021,337.8 мянга, борлуулсан 181,992.0 мянган төгрөгөөр буурсан.
- Үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдан авсан 79,272.8 мянга, үнэ төлбөргүй авсан 18,410.7 мянга, бараа материалаас хөрөнгийн дансанд шилжүүлсэн 7,407.1 мянга, акталсан 954,868.4 мянга, үнийг шинэчлэн тогтоосон 669,846.9 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгасантай холбоотой.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус хүрээлэн нь 2021 оны төсвийн төсөлд 2,667,757.0 мянган төгрөгийн урсгал зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 592,314.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 3,260,071.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн, 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,260,071.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 287,105.0 мянган төгрөгийг улсын төсвөөс 86,198.2 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, ЭМДС-аас 2,886,767.8 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвийн санхүүжилт 286,581.2 мянга, үндсэн үйл ажиллагаанаас 84,003.6 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 2,194.5 мянга, эрүүл мэндийн даатгалын сангаас 2,536,767.8 мянга нийт 2,909,547.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,907,196.0 мянган төгрөгийг зарцуулж үлдэгдэл 277.8 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,907,196.0 мянган төгрөг буюу 88.1 хувьтай байгаа нь ЭМДС-ийн санхүүжилтийн 312,812.2 мянган төгрөгийн авлага үүссэнтэй холбоотой байна.

Урсгал зардлын гүйцэтгэл батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулахад бүлгийн дүнгээр хэмнэлттэй харагдаж байна. Тухайлбал:

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийн дутуу зарцуулалт нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 54,302.9 мянга, байр ашиглалттай холбоотой зардал 21,006.9 мянга, хангамжийн бараа материал 24,832.1 мянга, нормативт зардал 163,464.0 мянга, эд хогшил урсгал засварын зардал 119,690.9 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс 95,295.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй

Нэмэлт санхүүжилтийн дансанд 1,721,282.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнд:

- Уламжлалт эм борлуулсны орлого 789,940.0 мянган төгрөг;
- Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс дадлагажигч эмч нарын санхүүжилтанд 676,024.3 мянган төгрөг,
- ЭМЯ-наас халдварт өвчний голомтонд ажилласан эмнэлгийн ажиллагсад санхүүгийн дэмжлэг үзүүлэх 191,575.6 мянган төгрөг,
- ШУТС-аас суурь судалгааны төслийн санхүүжилтийн орлого 34,123.1 мянган төгрөг
- Хими фармаклокийн судалгааны орлого 38,618.8 мянган төгрөг,
- Гадаадтай хамтарсан судалгааны төслийн санхүүжилт 9,399.7 мянган төгрөг,
- БШУЯ-наас 1,844.4 мянган төгрөг,
- Судалгааны ажлын гэрээний орлого 13,880.0 мянган төгрөг байна.

Үүнээс: Цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 1,032,541.0 мянга, байр ашиглалттай холбоотой зардал 1,993.7 мянга, хангамж бараа материалын зардал 40,323.1 мянган, нормативт зардал 249,893.6 мянга, эд хогшил худалдан авах зардалд 111,596.8 мянга, томилолтын зардалд 5,342.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 142,633.9 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 136,958.7 мянга, нийт 1,721,282.8 мянган төгрөг зарцуулж үлдэгдэл 7,909.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд байгууллагын хэрэгжүүлэх хөтөлбөр, төслийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээний хэрэгжилт 88.1 хувь, хөтөлбөр арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэлийн 100 хувийн биелэлттэй, 11.9 хувь буюу ЭМДС-ийн дутуу санхүүжилт 312,812.3 мянган төгрөгөөс шалтгаалсан байна.

Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрийн хүрээнд уламжлалт эмчилгээний тусламж үйлчилгээнд давхардсан тоогоор 4056 хүнд 1,831,163.9 мянган төгрөгөөр тусламж үзүүлсэн.

Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “ Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгааг нэгтгэн

дүгнэхэд төсвийн шууд захирагч нь 30 м2 талбайтай ажил уулзалтын өрөө, 79,428.6 мянган төгрөгийн 3 авто машинтай, Ковидтой холбоотой 385.0 мянган төгрөгийн яаралтай эм тариаг харилцагч байгууллагаас хандиваар хүлээн авч зарцуулсныг бүртгэлд тусган тайлагнасан.

3.8 Аудитын гол асуудал

Төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрийн дагуу Цар тахал /Ковид-19/-тай холбоотой Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт нь тайлант онд төлөвлөснөөс 1,102,263.2 мянган төгрөгөөр гүйцэтгэлд суурилан нэмж санхүүжүүлсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг тооцон мөнгөн хөрөнгийн журналын орлого, зарлагын гүйлгээг тулган Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацааны оруулбал зохих 350 мэдээллээс 334 мэдээллийг хугацаанд нь 6 мэдээ хугацаа болоогүй, 10 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан нь МУЕА-ын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/108 дугаар Шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл батлах тухай тушаалын 3 дугаар зүйлийн 3.1.7-д заасны дагуу зөрчлийн хэмжээ нь 7.8 хувь тул зөрчилд тооцоогүй болно.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант оны эхэнд баталсан төлөвлөгөөний дагуу 702,999.5 мянган төгрөгийн 10 худалдан авах ажиллагааг цахим системээр, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.2 болон 34.2.6 заалтуудын үндэслэн Коронавируст халдвар/Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 13.2.2 заалтуудыг тус тус үндэслэн 6 удаагийн 223,191.4 мянган төгрөгийг худалдан авалтыг шууд гэрээ зохион байгуулж ажилласан.

Сантехникийн засварын ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа гэрээний биелэлтийг хянаж, гэрээ дүгнэсэн акт үйлдэж, ажил хүлээлцэх комисс үр нөлөөтэй ажиллаж явцыг үе шатанд хянаж баримтжуулан ажиллаагүй 23,867.2 мянган төгрөгийн зөрчил нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 49 дүгээр зүйлийн 49.2.10-т “Гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичиг” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа гэрээний биелэлтийг хянаж, гэрээ дүгнэсэн акт үйлдэж, холбогдох хууль, дүрэм, журмыг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх, зөвлөмж өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, худалдан авах ажиллагааны зохион байгуулалт нь

ТБОНӨХБАУХАТХ-ийн 49 дүгээр зүйлийн 49.2.10-т “Гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичиг” гэсэн заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 784,131.1 нийт мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 784,131,1 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Өгсөн зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад 784,131.1 мянган төгрөгийн зөвлөмжийг хэрэгжүүлсэн ба 1 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн үндсэн хөрөнгө, бараа материалтай холбоотой 417,909.9 мянган төгрөгийн 4 зөвлөмжийг 100 хувь биелүүлж, эмийн үйлдвэрийн НБББББ-тай холбоотой зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй, хэрэгжилт 80 хувьтай байна.

Хүснэгт-4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	5	10,571.2	1	10,571.2	1		80.0
Нийт дүн	5	10,571.2	1	10,571.2	1		80.0

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн нь 2011 оны 02 дугаар сарын 21-ний өдөр ОХУ-ын Новая Ази компанитай уламжлалт эм худалдан авах 102,000.0 ам долларын гэрээ байгуулсан, үлдэгдэл төлбөр 38,638.1 мянган төгрөг санхүүгийн тайланд авлагаар бүртгэлтэй.

Гэрээний үлдэгдэл төлбөрийг төлүүлэхээр 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 173 дугаар шийдвэр гарч ОХУ-ын шүүхийн шийдвэр гүйцэтгүүлэх албанд албадан гүйцэтгүүлэх нэхэмжлэл гаргасан нь хэрхэн шийдвэрлэснийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 880,624.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 856,757.6 мянган төгрөгийн алдааг залруулж, өмнөх оны зөвлөмж эмийн үйлдвэрлэлийн НБББББ боловсруулж ажиллаагүй зэрэгт 1 албан шаардлага хүргүүлж, 23,867.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын дараах алдааны залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Ажилчдын цалингийн тооцооллыг ХАОАТ-тай тулган давтан тооцоолоход 472.2 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн;
2. Тайлант онд 35,856.7 мянган төгрөгийн худалдан авалтын цахим төлбөрийн баримтыг гаргуулан тайлант хугацаанд татварын цахим системд бүртгүүлсэн;
3. Бараа материалын тайлангийн эцсийн үлдэгдлийг 40.5 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн;
4. Бараа материалын дансанд бүртгэсэн 7,303.8 мянган төгрөгийн номын фондыг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн;
5. Эм боох материалын тайлангийн эхний үлдэгдэл 27.5 мянган төгрөгийн зөрүүтэйг зардлаар тайлагнасан;
6. Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд 1,749.5 мянган төгрөгийг илүү тусгасан;
7. Санхүүгийн тайлан хоорондын уялдааг шалгахад 811,307.4 мянган төгрөгийн зөрүү үүссэнийг тус бүр залруулан бүртгэсэн.

4.2 Албан шаардлага

Өмнөх онд эмийн үйлдвэрлэлийн орлого, зардал, өртгийг бүртгэх стандартад нийцсэн, өөрийн онцлогт тохирсон бодлогын баримт бичиг боловсруулан мөрдөж, ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь УСНББОУС 3-ын 7-д “Нягтлан бодох бүртгэлийн бодлого нь санхүүгийн тайланг бэлтгэж толилуулахдаа байгууллагын мөрддөг тусгай зарчим, суурь, дүрэм, журам, тогтсон практик юм”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалт, Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тоот тушаалаар батлагдсан журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.10-д “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																
1			Ажилчдын цалингийн тооцооллыг ХАОАТ-тай тулган давтан тооцоолоход 472.2 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн.		1	472.2	1	472.2								
2	Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн	АХГ-2022/65/НА-СТА-ТШЗ	Тайлант онд 35,856.7 мянган төгрөгийн худалдан авалтын НӨАТ-ын төлбөрийн цахим баримтыг гаргуулан тайлант хугацаанд татварын цахим системд бүртгүүлсэн.		1	35,856.7	1	35,856.7								

3		Бараа материалын тайлангийн эцсийн үлдэгдлийг 40.5 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн.		1	40.5	1	40.5									
4		Бараа материалын дансанд бүртгэсэн 7,303.8 мянган төгрөгийн номын фондыг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн.		1	7,303.8	1	7,303.8									
5		Эм боох материалын тайлангийн эхний үлдэгдэл 27.5 мянган төгрөгийн зөрүүтэйг зардлаар тайлагнасан.		1	27.5	1	27.5									
6		Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд 1,749.5 мянган төгрөгийг илүү тусгасныг залруулав.		1	1,749.5	1	1,749.5									
7		Санхүүгийн тайлан		1	811,307.4	1	811,307.4									

			хоорондын уялдааг шалгахад 811,307.4 мянган төгрөгийн зөрүү үүссэнийг тус бүр залруулан бүртгэсэн.												
8			Өмнөх онд эмийн үйлдвэрлэлийн орлого, зардал, өртгийг бүртгэх стандартад нийцсэн, өөрийн онцлогт тохирсон бодлогын баримт бичиг боловсруулан мөрдөж, ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй	Өмнөх оны зөвлөмж хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэх.						1					
Санхүүгийн тайлангийн аудитын дүн					7	856,757.6	7	856,757.6							
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал															
9			Шилэн дансны цахим хуудсанд 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.							1					
10			Тайлант онд 23,867.2		1	23,867.2								1	23,867.2

	Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн	АХГ-2022/65 /НА-СТА-ТШЗ	мянган төгрөгийн сантехникийн засварын ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа гэрээний биелэлтийг хянаж, гэрээ дүгнэсэн акт үйлдэж, ажил хүлээлцэх комисс үр нөлөөтэй ажиллаж явцыг үе шатанд хянаж баримтжуулан ажиллаагүй байна.												
Нийцлийн аудитын Дүн				1	23,867.2									1	23,867.2
Нийт дүн				8	880,624.8	7	856,757.6			1				1	23,867.2



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 36/АО150058

Улаанбаатар хот

АХТ-2022/65/НА-СТА-ТУИС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх онд эмийн үйлдвэрлэлийн орлого, зардал, өртгийг бүртгэх стандартад нийцсэн, өөрийн онцлогт тохирсон бодлогын баримт бичиг боловсруулан мөрдөж ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.

Энэ нь УСНББОУС 3-ын 7 "Нягтлан бодох бүртгэлийн бодлого нь санхүүгийн тайланг бэлтгэж толилуулахдаа байгууллагын мөрддөг тусгай зарчим, суурь, дүрэм, журам, тогтсон практик юм", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Эмийн үйлдвэрлэлийн орлого, зардал, өртгийг бүртгэх стандартад нийцсэн, өөрийн онцлогт тохирсон бодлогын баримт бичиг боловсруулан алдаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний аудитын газарт Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн Захирал Ч.Чимэдрагчаа, Ахлах нягтлан бодогч Г.Батчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Ч.ЭРДЭНЭЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

90 10 1 20 5396

\\G:\0_10_20\Bichig_Khorog\Alban_Shaardlaga\2022\0225_Auditin_2_Gazar-51.Docx

001080188

